



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ

11
АНГИ

МОНГОЛ ХЭЛ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:

Санамж:

- ✓ Монгол хэл, үндэсний бичиг, уран зохиолын 23 даалгаврыг 40 минутад гүйцэтгэх тул цагаа сайтар төлөвлөж бүх даалгаврыг ажиллаарай.
- ✓ Монгол хэлний даалгавруудыг гүйцэтгэхдээ эхийг уншиж, сайтар ойлгосон байхыг анхаараарай.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Ичээний нууц (эсээ)

Ирээдүйн мал аж ахуйг ичээний нууцад дулдуйдан хөгжүүлбэл өвөл нь хонь ямаа, үхэр адуу тэр байтугай тэмээг ч бэлчээрт гаргаж хариулах шаардлагагүй, тэжээл бэлтгэх ч хэрэгцээгүй болно. Зудын гайгаар мал хорогдох аюул ч алга болно. Өвлийн цагт малчин хүн боловсролоо дээшлүүлэх, эсвэл дулааны улиралд малаас авсан ашиг шимийг үйлдвэрийн аргаар боловсруулах ажил хийнэ. Цас, зудын эрхшээлээс мал аж ахуй бүрэн чөлөөлөгдөнө. Гагцхүү малыг өвөлжин ичээхэд орон байр шаардагдана. Ичээнд оруулах тусгай алба бий болно.

Манай нутагт тарвага хэрхэн ичдэгийн адил малыг ичээж хавар сэрээж гаргаж авна. Намрын таргаараа хавартай золгосон мал ичээнээс гарсны дараах хэд хоногт турж эцэх гэнэтийн хувиралтыг л давж чадвал байгалийн эрхшээлээс шалтгаалж мал хорогдохыг бараг үзэхгүй болгож болно. Өвлийн хөр цасан дундуур малын хойноос дагаж түгдчиж мачийдаг малчин хүний зүдрэл ч мартагдаж алга болно. Орон даяар элдэв хашаа хороо барьж жил бүр засаж сэлбэж, намар бүр өвлийн бэлтгэл хангах тухай ярих шаардлагагүй болно. Хамгийн гол нь өдий төдий өвс тэжээл бэлтгэж түүнийг аймаг, сум дамжуулан тээвэрлэж ажил удаж, гарз гаргадгаас чөлөөлөгдөнө. Хүн хүч, зардал төсөв хэмнэнэ. Байгалийн эрхшээлээс мал хүн хоёр айхаа болино.

...Тарвага өвөлжин ичээнд байж унтаж өнгөрөөсөн тэр хугацаандаа биеийн ямар ч өөрчлөлтгүй байдаг юм гэж үү? Наад захын амьдрах хугацаагаа уртасгадаг байж болох уу? Энэчлэнгээр асуулт олноороо л гарч эхэлнэ. Тарвага шиг өвөлжин ичээнд байхын тулд мал мөн л тарвага шиг таргалах ёстой. Тарваганы бүх жингийн гуравны хоёр нь өөхнөөс бүрэлддэгийн хүчинд өвлийн ичээг давдаг биз. Тэгвэл малыг намар болтол тэжээж тийм сайн таргалуулах хэрэгтэй. Тарвага шиг өөхний их ачааг мал өөрөө даадаг байхаар биеийн тэнцвэртэй болох шаардагдана. Ямаа гэхэд л гахай шиг тарган болж байж өвлийн ичээг дааж гарна. Гэтэл ямаа тийм болтлоо таргалж чадахгүй биз. Тэмээ ч гэсэн тэр дайны таргалах уу? Хэрвээ таргалуулж чадахгүй бол ичээний амьдралд дасахгүй. Ингэхээр ичээний амьдралд тэсэж чадах өөр төрлийн тэжээл боловсруулах хэрэг гарна. Тарилгын хэлбэрээр тийм тэжээл бэлдээд намар ичээний байдалд оруулах эмтэй хамт нэг мөсөн тарьж болно.

Ичээн өвөлжүүлэхэд зарим малд таарахгүй тийм зохилдлогоо байх нь баараггүй болохоор судалгааг нарийвчлан мачийж хийх хэрэг гарна. “Тарвага шиг таргалж, Тахиа шиг өндөглөх “гэдэг үг ирээдүйн мал аж ахуйн үр ашгийн үндсэн зарчим болох ёстой. Ичээнд байх цөөхөн сарын дотор мал үр төлөө хэвлийдээ тээх хугацаа дууссан байхаар, дөнгөж ичээнээс гармагц төллөхөөр зохион байгуулах хэрэгтэй болно. Ичээний таргаа бараагүй байх хугацаанд төлөө уургаараа цатгавал илүү үр дүнтэй биз. Үүнээс болж малын үрээ тээх хугацааг богиносгох гарвалийн ухааны нарийн ажил зайлшгүй шаардагдана. Тэр асуудлыг юунд тулгуурлах вэ? Дэлхий дээр анх үүссэн сүүн тэжээлтний дотроос эрж хайх уу? Тэгвэл хэвээрээ үлдсэнээс үү, хувирч өөрчлөгдсөнөөс нь үү? Олон сая жил хэвээрээ үлдэж, ямар ч хувирал үзээгүй амьтан дэлхий дээр бараг байхгүй. Ганцхан гэрэлзгэнэ гэдэг хулгана л бий шүү дээ. Гэвч гэрэлзгэнэ (землеройка) хулгана ганцаараа өвөл ичиж сурсангүй. Төрлийн нь бусад хулгана, хүцгэнэ цөм ичээндээ нойрсож байхад гэрэлзгэнэ гагцаар өвөлжин унтаж үл чадна. Нойргүй болчихсон хүн шиг гэрэлзгэнэ гагцаар гэгэлзэн өвөлжинө. Тэгэхээр бас ичдэг боломжгүй бие махбодтой байж мэдэх нь.

Ингэхэд ичих гэдэг маань юу билээ? Биеийн дулааныг хөлдөхөөс арай өмнө хүртэл алдаж бууруулан унтаж өнгөрөх гэсэн үг. Хагас хөшихөөс өөр ичээний хэлбэр бас бий. Тэр бол мөнх цасны нохой бөөсний амьдрах хэлбэр Глетчерная блоха буюу мөнх цасны нохой бөөс хөлдөж

үхэхгүйн тулд шөнөд биеэ халаах бүх хэрэгслээ ажилгүй болгодог. Тэгээд бүрмөсөн хөлдөж хонодог. Өглөө болж нар мандахад түүний хөлдсөн бие гэсэж дахин амь орж, үсчиж эхэлнэ. Мөнх цасны нохой бөөс жирийн нохой бөөснөөс хэд дахин илүү үсрэх чадвартай.

Хөдөлгөөний нь биш харин шөнө хөлдөөд өдөр гэсдэг чанарыг нь авч хэрэглэвэл ямар вэ? Амьтай болгон хөлдөж үхэж чадах боловч хөлдчихөөд дахин гэсэж амь ордог нь хэд билээ? Тийм амьтан байхгүй. Гэтэл мөнх цасны нохой бөөс хөлдөөд дахин гэсэж амь орно. Энэ чинь тун гайхамшигтай ховор чанар шүү дээ. Ийм юмнаас судлан санаа авах нь чухал. Өөр ямар <<Туршлага>> эсвэл үлгэр загвар байна.

Аа тийм! Ичээний амьтны цуснаас эрдэмтдийн нээж олсон шинэ зүйлийн нөлөөгөөр тэр амьтны биеийн илч нь нэг градус хүртэл буурч, зүрхний нь цохилт 98 хувь хүртэл удааширдаг байна. Бараг л зүрх нь зогсоно гэсэн үг. Тэр бодисыг малын цусанд холих тарилга болгон туршиж улмаар дасгалжуулбал хонь байтугай тэмээг ч ичээнд өвөлжүүлж болох юм биш биз?

Малыг тэгж ичээний амьдралд оруулаад зогсохооргүй сонин хэтийн төлөв бас үүнээс харагдаж байгаа юм. Ичээний амьтны цуснаас олсон шинэ бодисыг ашиглан хүний биеийн илчийг олон хоногоор бууруулж төвөгтэй хэцүү мэс заслыг сандрахгүй тайвнаар найдвартай хийж болно. Одоохондоо ичээний маягаар амьдрагчийн нууцыг ийм зүйлд ашиглахад хангалттай биш үү?

Малын тухайд бол энэ нь тун энэрэнгүй бөгөөд эдийн засагч бодол санаа биш гэж үү?

Л.Түдэв 1984 он

Монгол хэлний даалгаврууд

1. Эсээний сэдвийг олоорой.
 - A. Ирээдүйн мал аж ахуйг тарвагатай адил ичээн хөгжүүлэх боломжийн тухай
 - B. Ирээдүйн мал аж ахуйг өвөл хээлээ тээх хугацааг тохируулан ичээх боломжийн тухай
 - C. Ирээдүйн мал аж ахуйг өвөл ичдэг амьтдын цуснаас тарилга гарган авах замаар хөгжүүлэх боломжийн тухай
 - D. Ирээдүйн мал аж ахуйг ичээний нууцад дулдуйдан хөгжүүлэх боломжийн тухай
2. Малыг таргалуулж байгаад ичээх санааг илэрхийлсэн толгой өгүүлбэр аль вэ?
 - A. Ичээнд байх цөөхөн сарын дотор мал үр төлөө хэвлийдээ тээх хугацаа дууссан байхаар, дөнгөж ичээнээс гармагц төллөхөөр зохион байгуулах хэрэгтэй болно.
 - B. Манай нутагт тарвага хэрхэн ичдэгийн адил малыг ичээж хавар сэрээж гаргаж авна
 - C. Ингэхэд ичих гэдэг маань юу билээ? Биеийн дулааныг хөлдөхөөс арай өмнө хүртэл алдаж бууруулан унтаж өнгөрөх гэсэн үг.
 - D. Хагас хөшихөөс өөр ичээний хэлбэр бас бий.
3. “Малыг ичээндээ байх хугацаанд үр төлөө хэвлийдээ тээх хугацаа дууссан байх хэрэгтэй” гэсэн зохиолчийн санааг мухардуулсан баримтыг сонгоорой.
 - A. Тарваганы бүх жингийн гуравны хоёр нь өөхнөөс бүрэлддэгийн хүчинд өвлийн ичээг давдаг биз.
 - B. Гэвч гэрэлзгэнэ (землеройка) хулгана ганцаараа өвөл ичиж сурсангүй.
 - C. Мөнх цасны нохой бөөс жирийн нохой бөөснөөс хэд дахин илүү үсрэх чадвартай.
 - D. Малын тухайд бол энэ нь тун энэрэнгүй бөгөөд эдийн засагч бодол санаа биш гэж үү?
4. “Наад захын амьдрах хугацаагаа уртасгадаг байж болох уу?” гэсэн өгүүлбэрийн “наад зах”-ын гэсэн үг ямар утгаар орсон бэ?
 - A. наана гэсэн орны утга
 - B. зах хязгаар гэсэн орны утга
 - C. нэн тэргүүнд гэсэн цагийн утга
 - D. эцэст нь гэсэн цагийн утга

5. “Тарвага шиг таргалж, Тахиа шиг өндөглөх” гэсэн хэлцийг зохиолч ямар зорилгоор бичсэн бэ?
- A. Өнөөгийн мал аж ахуйн үр ашгийн үндсэн зарчим болох ёстой гэсэн санаагаа лавшруулах зорилготой
 - B. Ирээдүйн мал аж ахуйн үр ашгийн үндсэн зарчим болох ёстой гэсэн санааг үгүйсгэх зорилготой
 - C. Ирээдүйн мал аж ахуйн үр ашгийн үндсэн зарчим болох ёстой гэсэн санаагаа батлах зорилготой
 - D. Ирээдүйн мал аж ахуйн үр ашгийн үндсэн зарчим болох ёстой гэсэн санаагаа таамаглах зорилготой
6. Багш 11 дүгээр ангийн монгол хэлний хичээл дээр Л.Түдэв зохиолчийн “Ичээний нууц” эсээг уншуулан, хэлэлцүүлэг өрнүүлэв. Хэрэв чи зохиолчийн санаатай санал нэгдэж байвал дараах сэтгэгдлийн аль нь чинийх вэ?
- A. Мал аж ахуйг ичээний нууцад дулдуйдан хөгжүүлэх нь хаа хаанаа тун энэрэнгүй бөгөөд эдийн засагч арга байж болох юм.
 - B. Ичээн өвөлжүүлэхэд зарим малд таарахгүй тийм зохилдлогоо байх нь баараггүй болохоор судалгааг нарийвчлан мачийж хийх хэрэг гарна.
 - C. Тэмээ, үхэр, хонийг нохой бөөс шиг үргэлж үсчин үсэрдэг болгох гэж үү? Тэр ч барахгүй байх аа.
 - D. Мөн ичдэг амьтдаас зурмын зүрхний цохилт жирийн үедээ минутад 90 байдаг бол ичсэн үедээ 8-25 болж буурдаг.
7. Хэрвээ чи эрдэм шинжилгээний бүтээл бичихдээ Л.Түдэв зохиолчийн 2021 онд хэвлэгдсэн “Үгэн бороо” номын 31 дүгээр хуудсанд байгаа “Ичээний нууц” эсээнээс эш авсан бол ном зүйг яаж хийх вэ?
- A. Л.Түдэв, “Үгэн бороо”, УБ, 2021
 - B. Түдэв Л., Үгэн бороо, УБ, 2021
 - C. Л.Түдэв., “Үгэн бороо”, УБ, 2021
 - D. Түдэв Л. Үгэн бороо, УБ, 2021
8. “Нойргүй болчихсон хүн шиг гэрэлзгэнэ гагцаар гэгээлзэн өвөлжинө.” гэсэн өгүүлбэрийг цагийн утгаар дэлгэрүүлэхэд аль нь тохирох вэ?
- A. хулгана, хүцгэнэ цөм ичээндээ нойрсож байхад
 - B. хэдэн мянган жил ямар ч хувирал үзээгүй
 - C. олон сая жил хэвээрээ үлдсэн
 - D. хэн нэгнийг чих тавин хүлээж байгаа мэт
9. “Энэ хугацаанд төлөө уургаараа цатгавал илүү үр дүнтэй биз.” гэсэн өгүүлбэрийн гишүүн өгүүлбэрийг тодорхойлоорой.
- A. шууд бус тусагдахуун гишүүн өгүүлбэр
 - B. шууд тусагдахуун гишүүн өгүүлбэр
 - C. байц гишүүн өгүүлбэр
 - D. тодотгол гишүүн өгүүлбэр
10. Үгийн утгын тайлбар тольд толгой үгийг яаж тэмдэглэх вэ?
- A. дугуй хаалтад
 - B. бүх үсэг томоор
 - C. налууугаар *\italic*
 - D. тодоор **\bold**

Үндэсний бичгийн даалгаврууд

11. Шинжлэх ухааны тодорхойлолтыг зөв хөрвүүлсэн өгүүлбэр аль вэ?

ᠠ. Биет чичирхийлэхэд бөөрүүд нааш цааш хөлөрдөг.
ᠪ. Биет чичирхийлэхэд бөөмүүд нааш цааш хөдөлдөг.
ᠳ. Баяд чичирхийлэхэд бөөрүүд нааш цааш хөдөлдөг.
ᠷ. Биет чичирхийлэхэд бөөмүүд наашаа цаашаагаа хөдөлдөг.

- A. Биет чичирхийлэхэд бөөрүүд нааш цааш хөлөрдөг.
- B. Биет чичирхийлэхэд бөөмүүд нааш цааш хөдөлдөг.
- C. Баяд чичирхийлэхэд бөөрүүд нааш цааш хөдөлдөг.
- D. Биет чичирхийлэхэд бөөмүүд наашаа цаашаагаа хөдөлдөг.

12. “ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠢᠨᠭᠡᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠢᠨᠭᠡᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠢᠨᠭᠡᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠢᠨᠭᠡᠨ” өгүүлбэрийг уншаарай.

- A. Хутгыг хэрээр нь хүнд өгөхийг цааргалдаг.
- B. Хутгыг ирээр нь хүнд өгөхийг цээрлэдэг.
- C. Хутгыг ирээр нь гүнд өгөхийг цээрлэдэг.
- D. Утгыг ирээр нь хүнд өгөхийг цааргалдаг.

13. “ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ” хэмээх өвөрмөц бичлэгтэй үгийг кириллээр зөв хөрвүүлснийг олоорой.

- A. лонх
- B. жуух
- C. нуух
- D. лус

14. “ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ” хэмээх үгээс өөр язгууртай /төрөл биш/ үг аль вэ?

- A. суудал
- B. суусар
- C. сууц
- D. суурин

15. “зочлох ёс” гэсэн холбоо үгийг үндэсний бичгээр зөв бичсэнийг олоорой.

A. B. C. D.

Уран зохиолын даалгавар

16. “Махабхарата” туулийн “Түүний захиран суусан улс гүрэнд амар тайван, өлзий буян үлэмж байсан учраас Шива бурхны соёрхлоор хааны хатан Гандхари зуун сайн хүү төрүүлжээ” гэсэн хэсгийн хам сэдвийг олоорой.

- A. түүхийн хам сэдэв
- B. улс төрийн хам сэдэв
- C. нийгмийн хам сэдэв
- D. шашны хам сэдэв

17. Хэрэв чи А. Доде “Сүүлчийн хичээл” өгүүллэгийн “Эх хэл маань, үндэсний бичиг соёл маань энэ л улсын тусгаар тогтнолын баталгаа болоод байна, үүнийг хүн бүр ойлгох цаг нь болжээ.” гэсэн зохиогчийн санаатай санал нийлж байвал зохиолын аль хэсгийг өөрийн үзэл бодлоо батлах баримт болгон авах вэ?
- A. Хүүхдүүд ээ! Би та нартай сүүлчийнхээ хичээлийг хийж байна. Эльзас ба Лотарингийн сургуулиудад зөвхөн герман хэл заах шийдвэр Берлинээс ирсэн.
 - B. Учир нь, боолчлогдон дарлагдаж байгаа ард түмэн эх хэлээ эзэмшинэ гэдэг бол гяндангийн түлхүүрийг барьж байна гэсэн үг
 - C. Тэр өдөр Амель багш бидэнд шив шинэ жишээ бэлдэж ирээд “Франц, Эльзас, Франц, Эльзас” гэж их л эвтэйхэн бичжээ.
 - D. Тэгснээ самбар луу эргэн, цэрд авч, байдаг хүчээ шавхан, том үсгээр: “Франц мандтугай!” гэж бичив.
18. А.Чехов “Хамелеон” өгүүллэгээр нийгмийн ямар асуудлыг хөндсөн бэ?
- A. Нийгэмд шударга ёс, тэгш бус байдал газар авсан
 - B. Хүмүүс гэрийн тэжээмэл амьтнаа хайрлахаа больсон
 - C. Шүүх, шийдвэр гаргагчдын мэдлэг чадвар дутмаг болсон
 - D. Олон нийт өөрийн үзэл бодолгүй, аялдан дагагч болсон
19. А.Доде “Сүүлчийн хичээл” зохиолын би баатрын дүрийн өсөлтийг зөв дараалуулаарай.
- 1) Үнэт зүйлтэй болсон
 - 2) Алдаагаа ухаарсан.
 - 3) Бусдыг ойлгосон.
 - 4) Өөртөө тулгарсан асуудлаа олсон.
- A. 3, 2, 4, 1
 - B. 1, 2, 3, 4
 - C. 2, 4, 1, 3
 - D. 4, 1, 3, 2
20. О.Бальзак “Эцэг Горио” туужид Эцэг Горио ямар орчинд амь тавьсан бэ? Зохиолын гадаад орчныг гүйцээгээрэй. “Түшиг болж байгаа хүн байсан”
- A. Оюутнууд буюу Бьяншон, Растиньяк байсан
 - B. Охид нь буюу Анастизи, Дельфина байсан
 - C. Байшингийн эзэн Воке байсан
 - D. Байшингийн үйлчлэгч Сильвия байсан

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж:

- ✓ Хоёрдугаар хэсгийн даалгавар сонгох биш, харгалзуулах даалгавар тул хариултын хуудасны 2-р хэсэгт будаж тэмдэглээрэй.

2.1. Дүрс ялган бичих үгсийг зөв харгалзуулаарай.

- | | | | |
|---|--|---|-------------|
| a | | 1 | үр хүүхэд |
| b | | 2 | өр зээл |
| c | | 3 | үрж дуусга |
| d | | 4 | үүрийн туяа |

Хорин мянган жилийн тэртээ одоогийн Берингийн хоолой байгаа хэсгээр газар ихээр доош суун улмаар усанд автаж эхэлснээр хуурай газар аажмаар хоёр хэсэгт хуваагдах явц эхэлжээ. Ингэснээр ургамал, ан амьтан, хүмүүс, соёл ёс заншил, шашин шүтлэг, тэр ч байтугай өвчин гээд бүх зүйл тусгаар болж өөр өөрийн замаар хөгжих нөхцөл болжээ. Гэтэл Кристофер Колумби тэр нэгэн өдөр Сан-Сальводарын аралд бууснаар энэхүү тусгаар хоёр газрыг эргээд холбосон үйл явдал болсон байна. Ганц хүн энэ гайхамшигт үйл явдлыг бүтээж бас түүнийгээ өөрөө ч мэдээгүй гэхэд үнэхээр гайхалтай. Энэ нээлтээрээ Колумби дэлхий дахины анхаарлыг өөртөө татсан ба энэ нь одоо болтол үргэлжилсээр байгаа юм.

2.2. Мэдээллийн үнэн худлыг нягтлан тэмдэглээрэй.

№	Мэдээлэл	Үнэн	Худал
a	Хуурай газар аажмаар хоёр хэсэгт хуваагдах үйл явц Сан-Сальводарын хоолойд болсон.	1	2
b	Колумби Сан-Сальводарын аралд бууснаар дэлхий дахины анхаарлыг өөртөө татсан.	1	2
c	Кристофер Колумби ургамал, ан амьтан, хүмүүс, соёл ёс заншил, шашин шүтлэг, тэр ч байтугай өвчин гээд бүх зүйл тусгаар болж өөр өөрийн замаар хөгжих нөхцөлийг бүрдүүлж өгсөн.	1	2
d	Кристофер Колумби хоёр эх газрыг гүүрээр холбосон.	1	2
e	Кристофер Колумби хорин мянган жилийн тэртээ одоогийн Берингийн хоолой байгаа газрыг нээсэн.	1	2

2.3. Зохиолын хэсгүүдийг дүрслэх ур маягтай зөв харгалзуулаарай.

- a Түүний нүд лянхувын дэлбэ шиг, үс хав хар гол шиг бие цогцос нь уран налархай. 1 хүншүүлэл
- b Хурц хутга барьж
Хувьт өөрийн мөрний зузаан газраас
Хурднаа нэгэн хэсэг мах огтолсонд
Хотол үхэдхийж газарт унавай
Урссан цус нь булаг мэт болж байв 2 ихэсгэл
- c Харин газрыг цус бялдан
норгоход тэр их тоос суужээ. 3 төлөөлөл
- d Тогос шувуу баярын нулимс унаган донгодон тосоход... 4 адилтгал
- e Аяа, хар нүдэт минь, тэр зүүднийх шиг намайгаа бодоод
Элдэв юм битгий сана! Хагацахад сэтгэл хөндийрнө гэж